

**“Шарынгол”ХК-ийн 2014 оны үйлдвэрлэлийн  
үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны  
талаарх, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,  
ТУЗ-ийн ажлын тайлан  
/Б.Батмөнх ТУЗ-ийн дарга /**

**Нэг. 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар**

**1. 2014 оны Уулын ажлын зорилт түүний биелэлтийн тухай**

2014 оны уулын ажлыг АМГ-ын баталсан төлөвлөгөөний үндсэн хүрээнд , тооцоолсон чиглэлийн дагуу 2014-2015 оны өвөл олборлох нүүрсний нөөц бэлтгэх , цаашдаа 2015-2016 онд олборлох нүүрсний нөөц нээх зорилтуудыг хангах зорилгоор зохион байгуулж явууллаа.

2014 оны уулын ажлын үндсэн үзүүлэлтийн гүйцэтгэлийг хүснэгт №01-д , 2013 онтой харьцуулсан гүйцэтгэлийг хүснэгт №02-д үзүүлэв.

Хүснэгт -01

д/д	Үзүүлэлт	х/нэгж	Төл.	Гүйц.	Хувь
1	Нүүрс олборлолт	м.тн	1,200.0	749.7	62.5
2	Нүүрс борлуулалт	м.тн	1,120.0	707.3	63.2
3	Хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	5,560.0	7,729.9	139.0
	- Автаар	м.м <sup>3</sup>	4,560.0	6,949.4	152.4
	- Тээвэргүй	м.м <sup>3</sup>	1,000.0	780.5	78.1
4	Уулын цул	м.м <sup>3</sup>	6,483.1	8,306.5	128.1
	- Автаар	м.м <sup>3</sup>	5,483.1	7,526.0	137.3
	- Тээвэргүй	м.м <sup>3</sup>	1,000.0	780.5	78.1
5	Шидэлт	м.м <sup>3</sup>	600.0	404.2	67.4
	Өрөмдлөгийн ажил	м.у.м	60.0	47.2	78.7

Хүснэгт -02

д/д	Үзүүлэлт	Нэгж	2013 он	2014 он		2013 онтой харьцуулсан үзүүлэлт
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	738.8	1200.0	749.7	101%
2	Нүүрс борлуулалт	м.тн	740.4	1120.0	707.3	96%
3	Хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	3592.8	5560.0	7729.9	215%
	- Тээвэртэй	м.м <sup>3</sup>	3321.8	4560.0	6949.4	209%
	- Тээвэргүй	м.м <sup>3</sup>	271.2	1000.0	780.5	288%
4	Уулын цул	м.м <sup>3</sup>	4161.1	6483.1	8306.5	200%
5	Шидэлт	м.м <sup>3</sup>	527.1	600.0	404.2	77%
6	Өрөмдлөг	м.у.м	40.1	60.0	47.2	118%
7	Х.Х.Коэффициент	м <sup>3</sup> /тн	4.86	4.63	10.31	

Уулын ажлын гүйцэтгэлээс харахад 2014 онд хөрс хуулалт маш эрчимтэй хийгдсэн байна. Энэ нь хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэлээр 2013-2014 онд шинээр DX-700 гидро экскаватор , HD-465 маркийн 7ш Коматцу , DA-40 маркийн 3ш Doosan машин техникүүдийг ашиглалтанд оруулж ажиллуулсан нь уулын ажлын бүтээмжийг нэлээд өсгөх үндсэн нөхцөл болсон юм.

Уурхайн хөрс хуулалтын өмнөх он жилүүдийн хоцрогдлоос шалтгаалан нүүрсний үндсэн давхаргыг нээх хөрсний хэмжээ нэмэгдэж байгаа нь илчлэг өндөр чанартай нүүрсний нөөц нээхэд нэлээд цаг хугацаа шаардаж байгаа юм. Энэ нөхцөл байдал нь 2014 оны нүүрс олборлолтын явцад голлох бэрхшээл болсон юм.

2014 онд нүүрс олборлолт хийгдсэн талбайн нүүрсний давхаргуудын тогтоц тогтворгүй, чанарын үзүүлэлт хангалтгүй байсанаас хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний илчлэгийн үзүүлэлт шаардлага хангахгүй тохиолдол ихээр гарсан.

2014 оны нүүрс олборлолт явагдсан блок талбайнууд нь ерөнхийдөө геологийн таатай бус нөхцөлтэй байсан учраас нэмэлт ажиллагаа нэлээд шаардагдсан нөхцөлд олборлолт хийсэн нь нүүрс олборлолтын төлөвлөгөөнд гол нөлөөлсөн юм. Ялангуяа Ремнант блок, Грийв Ярд блокийн гарш хэсгийн нүүрсний давхарга, чулууны үеийн тогтоц тогтворгүй, нүүрсний давхаргын чулууны үеийн тоо ихэссэн / 11-12 үе /, илчлэг бага, үнслэг өндөр байлаа.

Уул геологийн хүндрэлтэй талбайнуудад олборлолт хийхдээ гидро экскаваторуудыг түлхүү ашиглан чулууны ялгалт байнга хийж блокуудын нүүрсийг илчлэгээр нь ангилан холилт хийх замаар чанарын үзүүлэлтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан.

2014 онд борлуулсан нүүрсний 83.7 хувийг Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудад өгсөн бөгөөд гэрээгээр төлөвлөснөөс 51.7 мян.тн нүүрс илүү нийлүүлсэн. Харин Эрдэнэт ГОК, Эрэл цемент, УБ төмөр зам зэрэг байгууллагуудад нийлүүлэх нүүрсний чанар шаардлага хангахгүй байснаас төлөвлөсөн хэмжээнд нийлүүлэгдээгүй.

2014-2015 оны өвөл 100,0 мян.тн нүүрсний бэлэн нөөцтэй онд шилжсэн юм.

## **2. Техник тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний тухай**

- 2014 онд нийт уулын үндсэн тоног төхөөрөмжүүдийн жилийн засварыг 95 хувь хийж гүйцэтгэсэн. Шинэ сэлбэг шүд, тросс компрессороос бусад сэлбэг материалыг хуучин актласан сэлбэг эд анги сэргээн засварлах замаар засварын ажлыг хийж дуусгав. Шинэ сэлбэг авах захиалах ажлыг хийсэн боловч эдийн засаг санхүүгийн нөхцлөөс экскаваторуудад зориулж сэлбэг худалдан аваагүй байна.
- Технологи дамжлагын засварын ажлыг 6-р сард 23 хоногт багтаан хийв.
- Цахилгаан экскаваторуудын хөдөлгүүрүүдэд 2014 онд 25 удаа засвар хийгдэж 745 цаг зогссон байна. Шалтгааныг судлаж үзэхэд хамгийн их нөлөөлсөн шалтгаан нь хөдөлгүүрүүд олон жил ашиглагдаж элэгдэж муудсанаас хөдөлгүүрийн холхивч эвдэрч байсан нь нийт зогсолтын 56 хувийг эзлэж байна. Цахилгааны холболт, үзлэг үйлчилгээний чанараас 32 хувь нь хамаарсан байна. Ороомгын материалын чанараас хамаарсан эвдрэл эрс багассан байна.
- Вагон маневрт ашиглагддаг ТЭМ-2 илчит тэрэгний ТО-3 засвар үйлчилгээг 11-р сард Дарханы депод хийлгэсэн.

- 2014 онд авто тээврийн машинууд нийт 7526.0 мян.м3 уулын цул тээвэрлэсэн байна. Тайлант онд тээврийн хэрэгслүүдэд форсунка гацах, хөргөлтийн радиотор цоорох, амортизатор суух, тосолгооны системийн аппарат солих, агаарын хоолойн даруулага мултрах, мэдрэгчүүд болон сальникууд сэтрэх, редуктор шинээр тавих зэрэг голлох гэмтлүүд гарсан байна. Шинэ машинууд баталгаат хугацаандаа ийм их эвдрэл гарч сэлбэг материал их хэмжээгээр зарцуулагдаж байгаа нь ашиглалтын зардал ихсэж, ашиглахад хүндрэлтэй нь ажиглагдаж байна. Энэ байдал ялангуяа DOOSAN DA-40 №45,46, 47 маркийн өөрөө буулгагч машинуудад голлон харагдаж байна.
- Nord Benz машинууд эвдрэл их гарч байсанаас № 01,02,23,04 машинууд 3-6 сар зогссон байна.
- Харин HD-465, Doosan DA-40 маркийн машинуудын техник үйлчилгээг цаг тухай бүрд хийж, сэлбэг материалаар хангаснаар зогсолт саатал бага ажилласан байна.
- Бульдозер, авто ачигч, грейдер, зам усалгааны машин, авто кран зэрэг уулын туслах техникүүд жилийн хугацаанд ажил саатуулалгүй ажилласан байна.

### 3. 2014 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны тухай

№	Үзүүлэлтүүд	х/нэгж	2014 он
1	ХАБЭА-н ажилд төлөвлөсөн зардал	мян.төг	459 055 000
	Зардлын гүйцэтгэл		196 795 458
	Үүнээс: хувцас, хамгаалах хэрэгсэл		140 904 882
	Ажлын байруудын тэмдэг, тэмдэгжүүлэлтэнд		1 164 651
	Эрүүл ахуйн ажилд зарцуулсан зардалд		63 444 51
	Галын АА-г хангах нөөц бүрдүүлэлтэнд		26 15 790
	ХАБЭА-н сургалтын зардалд		12 185 000
	Хяналтын камерийн зардалд		-
	Аврах тасгийн зардалд		34 785 000
	Ажиллагсдын эрүүл мэндийн бүрдмэл үзлэг, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжруулахад		15 992 000
2	ХАБЭА-н сургалт	хүн	
	ХАБЭА-н мэргэшүүлэх сургалт		20
	ХАБЭА-н нийт ажилтны сургалт		342
	Урьдчилсан зааварчилгаа		-
	Давтан зааварчилгаа		-
	ХАБЭА-н сэдэвчилсэн сургалт		41
	Шинээр боловсруулж нэвтрүүлсэн бодлого, журам, горим		ширхэг
3	Үйлдвэрийн осол, тохиолдлын талаар	тохиолдол	
	Үйлдвэрлэлийн осол		6
	Эмнэлгийн тусламж авсан гэмтэл		7
	Автомашинны ослын тохиолдол		-
	Галын тохиолдол		2
	Өмчийн эвдрэлийн тохиолдол		12

Уурхайн 2015-2019 оны уулын ажлын өрнөлтийн хэтийн чиглэлийн төсөл

Бүгд	2019	2018	2017	2 оны дүн	2016	2015	Он	
							Өмнөд блок	Хойд блок
450			200	250	140	110	Нүүрс	Өмнөд блок
2850			1450	1400	650	750	Хөрс	Хойд блок
6.3			7.3	5.6	4.6	6.8	К.	Хойд блок
450			-	450	200	300	Нүүрс	Хойд блок
2400			-	2400	900	1500	Хөрс	Хойд блок
4.7			-	4.7	4.5	5.0	К.	Хойд блок
250			150	100	-	100	Нүүрс	Төв блок
1450			930	520	-	520	Хөрс	Төв блок
5.8			6.2	5.2	-	5.2	К.	Төв блок
1500	50	600	-	850	460	390	Нүүрс	Төв блок
13410	3950	3900	1600	3960	1800	2160	Хөрс	Төв блок
8.9	79.0	6.5	-	4.6	3.9	6.3	К.	Төв блок
900	450	-	350	100	100	-	Нүүрс	Төв блок
14080	3630	3630	1600	5220	3500	1720	Хөрс	Төв блок
15.6	8.1	-	4.6	52.2	35.0	-	К.	Төв блок
1050	500	400	150	-	-	-	Нүүрс	Төв блок
9820	3800	3600	2420	-	-	-	Хөрс	Төв блок
9.4	7.6	9.0	16.1	-	-	-	К.	Төв блок
4650.0	1000	1000	850	1800	900	900	Нүүрс / м.тн /	Шаазгайг хэсэг
44010.0	11380.0	11130.0	8000.0	13500.0	6850.0	6650.0	Хөрс / м.м3 /	Дүн
9.5	11.4	11.1	9.4	7.5	7.6	7.4	Коеф (Кр)	

	Он	Нүүрс олборлолт, хөрс хуулалт			Техник шинэчлэлт / хөрөнгө оруулалтаар /	
		Хөрс /мян.м3/	Нүүрс /мян.тн/	коэф	Экскаватор	Автомашин /HD-465/
1	2015	6650.0	900.0	7.4	-	-
2	2016	6850.0	900.0	7.6	-	-
3	2017	8000.0	850.0	9.4	1	2
4	2018	11130.0	1000.0	11.1	1	2
5	2019	11380.0	1000.0	11.4	-	-
Бүгд		43710.0	4550.0	9.6	2	4

Жич: 2017 онд DX-700 маркийн 1ш, 2018 онд PC-1250 юмуу эсвэл 10 м3 шанагатай цахилгаан экскаватор байхаар тооцож байна.

### 2015 оны уулын үйлдвэрлэлийн үндсэн зорилт

1. Жилдээ 900.0 мян.тн нүүрс олборлох уулын ажлын өрнөлтийг хангах
2. Жилдээ 6650.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулах, үүнээс 5970.0 мян.м<sup>3</sup> хөрс авто тээврээр, 680.0 мян.м<sup>3</sup> хөрс тээвэргүй хуулахаар төлөвлөсөн.
3. Нийт нүүрс олборлолт 900.0 мян.тн  
Нүүрс борлуулалт 900.0 мян.тн
4. 2015-2016 оны өвөлд 150.0 мян.тн-с багагүй нүүрсний бэлэн нөөцтэй шилжинэ.
5. Нийт хөрөнгө оруулалт ~~733.950.15~~ мян.төг
6. Хүү, элэгдэл хорогдол, татварын өмнөх ашиг ~~8.717.334.87~~ мян.төг
7. Уулын ажлын горимыг эдийн засгийн үр ашигт уялдуулан зохион байгуулж явуулна.
8. Уул техникийн болон үйлдвэрлэлийн осол авааргүй ажиллана.
9. 2015-2019 оны уулын ажлын өрнөлтийн бэлтгэл хангана.
10. Уулын ажлын ойрын жилүүдийн өрнөлттэй уялдуулан карьерийн ус шүүрүүлэлтийн асуудлыг шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
11. Блокуудын чанар муу нүүрсийг олборлон баяжуулах үйлдвэрээр боловсруулан борлуулах ажлыг зохион байгуулна.
12. Нүүрсний блокуудын нөөцийг аль болох үр ашигтай олборлох технологийн тооцоололт хийж хэрэгжүүлнэ.

## Хоёр. Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Нэг. Санхүүгийн тайлан баланс

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН /аудитлагдаагүй/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү (+) (-)	
				Мөнгөн дүнгээр	Эзлэх хувь
1	<b>ХӨРӨНГӨ</b>				
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,310,853,108.36	909,532,643.23	(4,401,320,465.13)	1.27
1.1.2	Бусад эргэлтийн хөрөнгө	12,814,639,526.39	15,672,809,204.28	2,858,169,677.89	21.93
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>18,125,492,634.75</b>	<b>16,582,341,847.51</b>	<b>(1,543,150,787.24)</b>	<b>23.21</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
1.2.1	Үндсэн хөрөнгө	23,063,892,244.37	23,945,659,918.18	881,767,673.81	33.51
1.2.2	Биет бус хөрөнгө	40,563,721.14	290,216,831.65	249,653,110.51	0.41
1.2.3	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,755,033,404.65	2,535,794,204.69	-219,239,199.96	3.55
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	15,529,587,902.58	28,100,419,548.38	12,570,831,645.80	39.33
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>41,389,077,272.74</b>	<b>54,872,090,502.90</b>	<b>13,483,013,230.16</b>	<b>76.79</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,514,569,907.49</b>	<b>71,454,432,350.41</b>	<b>11,939,862,442.52</b>	<b>100.00</b>
2	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн дүн</b>				
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>				
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
2.1.1.1	Дансны өглөг	8,916,620,471.10	8,066,264,310.48	-850,356,160.62	11.29
2.1.1.2	Богино хугацаат зээлийн өглөг		2,639,840,000.00	2,639,840,000.00	3.69
2.1.1.3	Бусад өглөг	867,702,371.94	1,912,659,365.02	1,044,956,993.08	2.68
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>9,784,322,843.04</b>	<b>12,618,763,675.50</b>	<b>2,834,440,832.46</b>	<b>17.66</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	7,467,030,000.00	14,142,000,000.00	6,674,970,000.00	19.79
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр	4,096,273,760.66	11,129,785,365.77	7,033,511,605.11	15.58
2.1.2.20	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,563,303,760.66</b>	<b>25,271,785,365.77</b>	<b>13,708,481,605.11</b>	<b>35.37</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>21,347,626,603.70</b>	<b>37,890,549,041.27</b>	<b>16,542,922,437.57</b>	<b>53.03</b>
2.3	<b>Эзэмшигчдийн өмч</b>				
2.3.1	Өмч а) төрийн				
2.3.2	б) хувийн	1,023,138,900.00	1,023,138,900.00	0.00	1.43
2.3.3	Бусад	33,325,042,518.81	31,991,836,555.01	(1,333,205,963.80)	44.77
2.3.4	Хуримтлагдсан ашиг, алдагдал	3,818,761,884.98	548,907,854.13	(3,269,854,030.85)	0.77
2.3.20	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>38,166,943,303.79</b>	<b>33,563,883,309.14</b>	<b>(4,603,059,994.65)</b>	<b>46.97</b>
2.5.20	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>59,514,569,907.49</b>	<b>71,454,432,350.41</b>	<b>11,939,862,442.92</b>	<b>100.00</b>

### ОРЛОГЫН ТАЙЛАН

	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	Зөрүү төг	
				Мөнгөн дүнгээр	Хувиар
1	Борлуулалтын орлого	21,802,708,343.69	19,728,267,402.04	(2,074,440,941.65)	90.49
2	Борлуулалтын өртөг	12,246,159,091.20	14,138,182,204.42	1,892,023,113.22	115.45
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>9,556,549,252.49</b>	<b>5,590,085,197.62</b>	<b>(3,966,464,054.87)</b>	<b>58.49</b>
4	Бусад орлого	2,218,407,530.1	-569,320,695.49	(1,649,086,834.61)	25.66
5	Борлуулалт, марктенгийн зардал	281,450,355.22	385,454,184.55	104,003,829.33	136.95
6	Ерөнхий удирдлагын зардал	6,074,371,852.09	5,526,769,280.44	(547,602,571.65)	90.99
7	Санхүүгийн зардал		193,200,270.03	193,200,270.03	
8	Бусад зардал	2,690,735,063.12	2,340,265,476.03	(350,469,587.09)	86.97
9	Валютын ханшны өөрчлөлтөөс	(388,413,129.43)	(1,322,836,916.16)	(934,423,786.73)	340.57
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(478,375,538.89)	(17,074.87)	478,358,464.02	0.00
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	<b>1,861,610,843.84</b>	<b>(3,609,137,308.97)</b>	<b>(5,470,748,152.81)</b>	<b>-193.87</b>
12	Орлогын татварын зардал	703,645,165.50	7,049,461.46	(696,595,704.04)	1.00
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,157,965,678.34</b>	<b>(3,616,186,770.43)</b>	<b>(4,774,152,448.77)</b>	<b>-312.29</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	Зөрүү (+) (-)
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
1.1	Бараа борлуулалсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	25,018,548,818.26	18,030,583,528.51	(6,987,965,289.75)
1.1.1	Бусад мөнгөн орлого	65,421,820.85	542,912,653.67	477,490,832.82
1.2	Мөнгөн зарлагын дүн	(41,858,611,653.95)	(22,437,069,469.04)	19,421,542,184.91
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,774,641,014.84)</b>	<b>(3,863,573,286.86)</b>	<b>12,911,067,727.98</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>453,911,911.17</b>	<b>(6,482,833,211.59)</b>	<b>(6,936,745,122.76)</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	518,975,150.17	939,580,699.92	420,605,549.75
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		163,000,000.00	163,000,000.00
2.1.2	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого		683,001,143.35	683,001,143.35
2.1.3	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		35,872,220.55	35,872,220.55
2.1.4	Хүүний орлого	518,975,150.17	57,707,336.02	(461,267,814.15)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(65,063,239.00)	(7,422,413,911.51)	(7,357,350,672.51)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(64,363,239.00)	(4,826,545,270.01)	(4,762,182,031.01)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		(189,921,732.98)	(189,921,732.98)
2.2.3	Урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		(2,405,946,908.52)	(2,405,946,908.52)
2.2.4	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(700,000.00)		700,000.00
2.2.5	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны			
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>6,613,190,326.57</b>	<b>5,945,086,033.32</b>	<b>(668,104,293.25)</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,123,458,577.41	16,267,451,104.55	9,143,992,527.14
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,943,165,920.00	16,070,486,059.85	9,127,320,139.85
3.1.2	Валютын ханшны тэгшитгэлийн ашиг	180,292,657.41	196,965,044.70	16,672,387.29
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(510,268,250.84)	(10,322,365,071.23 )	(9,812,096,820.39 )
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		(7,772,823,520.25)	(7,772,823,520.25)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт өгсөн		(2,471,664,332.80)	(2,471,664,332.80)
3.2.3	Төлсөн ногдол ашиг	(471,426,857.05)		471,426,857.05
3.2.4	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(38,841,393.79)	(77,877,218.18)	(39,035,824.39)
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(9,707,538,777.10)</b>	<b>(4,401,320,465.13)</b>	<b>5,306,218,311.97</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>15,018,391,885.46</b>	<b>5,310,853,108.36</b>	<b>(9,707,538,777.10)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,310,853,108.36</b>	<b>909,532,643.23</b>	<b>(4,401,320,465.13)</b>

Хоёр: Нүүрс борлуулалтын талаар:

Нүүрс борлуулалтын байдлыг томоохон хэрэглэгчээр нь аваад үзвэл:

мян.тн-оор

Хэрэглэгч	Гэрээгээр өгөх	Гэрээгээр өгсөн	Зөрүү	Хувь
Дархан ДЦС	290.0	289.58	0.42	
Эрэл цемент	69.0	14.34	54.66	
Дулаан ШГ	15.0	12.62	2.38	
Нако түлш	72.0		72.0	
Эрдэнэт Гок	115.0	55.0	60.0	
Эрдэнэт ДЦС	254.14	301.46	-47.32	
Улаанбаатар төмөр зам	95.0	2.52	92.48	
Хөтөл Цемент	125.0		125.0	
Авгаар борлуулалт	35.7	22.36	13.34	
Бусад	49.16	9.46	39.7	
<b>Дүн</b>	<b>1,120.0</b>	<b>707.34</b>	<b>-412.66</b>	<b>63.1</b>

Нүүрсний үнийг илчлэгтэй холбож өсөх буурах зарчмаар тооцоо хийхээр гэрээнд тусгагдсаны дагуу үнээ тооцож ажилласан бөгөөд нүүрсний чанартай холбоотойгоор 2014 оны эхний хагас жилд нийт 1,316.6 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Хэрэглэгч	Илчлэгээс	Жингийн зөрүү	Чулуулаг	Дүн
Дархан ДЦС	342.3	11.2		353.5
Эрдэнэт ДЦС	873.1	15.3	2.0	890.4
Эр Гок		5.3	5.9	11.2
Эрэл Цемент	32.9			32.9
Бусад			28.6	28.6
<b>Дүн</b>	<b>1,248.3</b>	<b>31.8</b>	<b>36.5</b>	<b>1,316.6</b>

**Гурав: Нүүрсээр авах авлагын тухай**

Нүүрсний авлагын дүнд томоохон жин эзэлж буй компануудыг хүснэгтээр харуулбал:

сая.төгрөг

Байгууллага	Оны эхний үлдэгдэл	2014 онд авсан	2014 онд төлсөн	Оны эцэст
Дархан ДЦС	101.3	8,075.2	7,713.6	462.9
Эрэл цемент	-10.6	681.0	655.7	14.7
Эр Гок		2,745.3	1,991.4	753.9
Нако түлш	186.5	3.0	96.0	93.5
Дулаан ШГ	186.4	485.4	313.9	357.9
Эрдэнэт ДЦС	45.2	7,836.2	7,598.3	283.1

**Дөрөв: Өр төлбөрийн талаар:**

Нийт өглөгийн 34,7%-ийг богино хугацаат өр төлбөр, 65,3%-ийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Өр төлбөр нь оны эхнээс 15,051.1 сая төгрөгөөр өссөн нь урт болон богино хугацаат зээлүүдээс шалтгаалж байна.

**Богино хугацаат өр төлбөр**

Дансны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)	Эзлэх хувийн жин
Дансны өглөг				
Дансны өглөг /бусад үйлчилгээний/	381,631,411.77	901,607,208.74	519,975,796.97	11.18
Нүүрсний өглөг 60-1	23,563,104.08	23,073,032.13	(490,071.95)	0.29
Сэлбэг материалын өглөг 60-2	2,566,559,845.14	1,779,171,530.12	(787,388,315.02)	22.06
Түрээсийн өглөг	5,918,674,732.17	5,287,495,194.27	(631,179,537.90)	65.55
Хүмүүст өгөх өглөг	26,191,377.94	74,917,345.22	48,725,967.28	0.93
<b>Бүлгийн дүн :</b>	<b>8,916,620,471.10</b>	<b>8,066,264,310.48</b>	<b>(850,356,160.62)</b>	<b>100.00</b>



*Урт хугацаат өр төлбөр*

Дансны зориулалт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт(-)	Эзлэх хувийн жин
Урт хугацаат зээл	MNT	7,467,030,000.00	14,142,000,000.00	6,674,970,000.00	76.03
	USD	4,500,000.00	7,500,000.00	3,000,000.00	
Санхүүгийн түрээс	MNT	0.00	4,458,997,753.90	4,458,997,753.90	23.97
	USD	0.00	2,364,763.34	2,364,763.34	
<b>Бүлгийн дүн :</b>	MNT	<b>7,467,030,000.00</b>	<b>18,600,997,753.90</b>	<b>11,133,967,753.90</b>	<b>100.00</b>
	USD	<b>4,500,000.00</b>	<b>9,864,763.34</b>	<b>5,364,763.34</b>	

*Тав: Нэмэгдсэн үндсэн хөрөнгө*

2014 онд 4,304.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Үүнд:

- Доосан экс 700LC	567.1
- Грейдер G-655	533.9 /санхүүгийн түрээс/
- Майги машин 4 ш	88.2
- Биет бус хөрөнгө	257.0
- Тавилга эд хогшил	38.0
- Тоног төхөөрөмж	24.9
- Капиталжуулсан хөрөнгө	2,585.3
- Амрах байр	205.4
- Компьютер, принтер	4.8

*Зургаа. ТАТВАР ТӨЛӨЛГИЙН ТАЛААР*

2014 онд 3,794.5 сая төгрөгийн татварыг улс болон орон нутгийн төсөвт төлөхөөс 3,418.5 сая төгрөгийг татварт, Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 441.8 сая төгрөг төлөхөөс 1,529.6 сая төгрөг төлөхөөс 1,292.6 сая төгрөгний төлсөн байна.

/сая.төг/

Татварын төрөл	Эхний үлдэгдэл	Төлбөл зохих	төлсөн	Эцсийн үлдэгдэл
Байгууллагын орлогын албан татвар	36.3	230.8	125.2	141.9
Хүн амын орлогын албан татвар	22.8	698.1	721.0	-
Иргэний орлогоор тодорхойлох	68.0	48.6	116.6	-
НӨАТ	-	2,145.1	1,847.8	297.2
Нөөцийн албан татвар	127.8	493.2	430.9	190.1
Тээврийн хэрэгслийн албан татвар	-	6.5	6.5	-
Газар ашигласны төлбөр	-	40.2	40.2	-
Ус ашигласны төлбөр	-	95.8	95.8	-
Үл хөдлөх хөрөнгийн татвар	(4.4)	36.2	31.8	-
<b>Дүн</b>	<b>250.5</b>	<b>3,794.5</b>	<b>3,418.5</b>	<b>629.2</b>
<b>НДШ</b>	<b>204.8</b>	<b>1529.6</b>	<b>1292.6</b>	<b>441.8</b>

**Гурав: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн  
ажил (засаглал)-ын талаар**

“Шарын гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6, хараат<sup>Бүг</sup> 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ. Энэ нь компанийн засаглалын үндсэн чиглэл байв.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2014 онд гишүүдийн оршин суугаа орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 11 удаа хуралдаж 19 тогтоол батлагдаж гарсан.

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ангилан авч үзвэл:

а. Компанийн 2014 оны бизнес төлөвлөгөө, компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цаашлын өрнөл хөгжлийг тодорхойлох 5 жилийн бодлого төлөвлөгөө боловсруулах ажлын комисс байгуулах тухай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой 4 асуудал.

б. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай аудитлагдсан санхүүгийн тайлангийн тухай, зээл авах тухай, гарын үсэг баталгаажуулах, түрээсийн гэрээ байгуулах, нүүрсний үнийг шинэчлэн тогтоох зэрэг компанийн санхүү эдийн засагтай холбоотой 9 асуудал.

в. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох, компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх, томилох, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийг батлах, компанийн салбар төлөөлөгчийн газар байгуулах зэрэг компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 5 асуудал.

г. Шарын голын уурхай үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтажхийх ажил, ойг тэмдэглэх бэлтгэл ажлын хэсэг байгуулах зэрэг бжсад асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.

➤ ТУЗ-ийн хурлаас гаргасан зарим тогтоолын биелэлт хэрэгжилтийг дурьдвал:

Компанийн ТУЗ-ийн хурлаар 2014 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж жилдээ 5,560,0 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 1,200,0 мян.тн нүүрс олборлож борлуулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 7,729,9 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 749,7 мян.тн нүүрс олборлож 707,3 мян.тн нүүрс борлуулсан байна. Энэ нь 2013 оны жилийн гүйцэтгэлээс 4,137,1 мян.м<sup>3</sup> хөрс илүү хуулж, 10,8 мян.тн нүүрс илүү олборлон, 33,1 мян.тн нүүрс дутуу борлуулсан байна.

Уулын ажлын гүйцэтгэлээс харахад 2014 онд хөрс хуулалт эрчимтэй хийгдэж, ялангуяа, авто тээврээр хуулах хөрсний дээд амжилтыг тогтоолоо.

Үүнд 2013, 2014 оны хөрөнгө оруулалтаар шинээр ашиглалтанд оруулсан техникийн парк шинэчлэл түүний хүчин чадал өндөр байсан нь нөлөөлсөн юм. Үүний үр дүнд авто тээврээр хуулах хөрс хуулалтын төлөвлөгөөг 152,4 хувиар биелүүлсэн боловч тээвэргүй системээр хөрс хуулах экскаваторын эвдрэл, нүүдэл хүлээн саатсан зогсолт зэргээс

бусад зардал (ажиллах хүч, түлш, тос, сэлбэг, зээлийн хүү гэх мэт)-д 1,827,348,889.17 төгрөг нийт 10,938,202,410.17 төгрөгийг гэрээний дагуу зарцуулаад байна.

- ❖ ТУЗ-ийн хурлын шийдвэрээр компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор “Файрбөрд Монголиа Холдинг”, “Эс Эйч Жи Холдинг-2”, “Нихан Холдинг” зэрэг сангаас нийт 900,000,0 ам.долларын зээл авсан бөгөөд Хай Би Ойлд зээлийн төлбөр, “Си Би Эм”-ийн үйлчилгээний болон менежментийн хөлс, DX700 түрээсийн хөлс, усны тоолуурын үнэ, Vulcan программ хангамжийн зардал зэрэгт нийт 1,683,650.13 төгрөг зарцуулаад байна.
- ❖ ТУЗ-ийн хурлаас 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цаашдын өрнөл, төлөвлөгөөний төсөл, 2020 он хүртлэх 5 жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах комисс томилон ажиллуулах шийдвэр гаргасан.  
Уг шийдвэрийн дагуу гүйцэтгэх удирдлага бүхий комисс томилогдон ажиллаж 2015 оны төлөвлөгөөний төсөл батлагдаж хэтийн үйл ажиллагааны төсөл боловсруулах ажил хийгдэж байна.
- ❖ ТУЗ-ийн хурлаар Гүйцэтгэх захирал Грам Чапманыг 6-р сарын 20-ны өдрөөр өөрийн хүсэлтээр нь чөлөөлж Б.Батбаатарыг мөн өдрөөс Гүйцэтгэх захирлаар томилон ажиллуулж байна.
- ❖ Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр батлан өөрчилсөн.
- ❖ Мөн ТУЗ-ийн хурлаас, компанийн үйлдвэрлэлийн үндсэн бүтээгдэхүүн болох нүүрсийг борлуулах ажлыг эрчимжүүлэн компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилгоор компанийн төлөөлөгчийн газрыг байгуулах шийдвэр гаргасны дагуу Төлөөлөгчийн газрыг УБ хотод байгуулж уг газрын ажиллах журмыг батлаж улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.
- ❖ ТУЗ-ийн хурлын тогтоолоор “Трансвест Монголиа” ХХК-аас худалдан авсан тоног төхөөрөмжийг дахин санхүүжүүлэх зорилгоор Ти Ди Би Лизинг ХХК-тай, тодорхой нөхцлөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулан ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад даалгасан. Энэхүү шийдвэрийн дагуу 4,183,845.77 ам.долларын зээлийг 30 сарын хугацаагаар авч Комацу машины түрээс, засварын зардал, машины даатгал зэрэгт нийт 4,183,845.77 ам.долларыг зарцуулсан байна.
- ❖ ТУЗ-ийн хурлын шийдвэрээр 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс харилцагч байгууллага, хэрэглэгчдэд нийлүүлэх 1 тонн нүүрсний үнийг 20,000 төгрөгөөр нэмж борлуулах тогтоол гаргасан. Шийдвэрийн дагуу 11, 12, 1 саруудад шинэчилсэн үнээр борлуулалт хийснээр 85,131,7 мянган төгрөгийн орлогыг нэмж олсон. Мөн Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудад нийлүүлэх 1 тонн нүүрсний татваргүй суурь үнийг 2014 оны 12 сарын 10-ны өдрөөс 30,000 төгрөгөөр тооцож мөрдөхөөр шийдвэр гаргасан.  
Уг шийдвэрийн дагуу 12 сарын 10-аас хойш 1 сарыг дуустал хугацаанд шинэчилсэн үнээр нүүрс нийлүүлснээр 425,795,9 мянган төгрөгийг нэмж олсон үзүүлэлттэй байлаа.
- ❖ Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр зарлан хуралдуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар :

шалтгаалан тээвэргүйгээр хуулах хөрсний төлөвлөгөө 78,1 хувийн биелэлттэй байсан. Нүүрс олборлолтын төлөвлөгөө тасалдсан гол шалтгаан нь нүүрс олборлохоор төлөвлөгдсөн мөргөцгийн урд хэсэг, Хойт блокын гаршийн нүүрсний давхарга, чулууны үеийн тогтоц тогтворгүй, чулуулгийн үеийн тоо ихэссэн. Мөн илчлэг бага, үнслэг өндөр үзүүлэлттэй зэрэг нь нөлөөлсөн юм.

2014 онд борлуулсан нүүрсний 83,7 хувийг Дархан, Эрдэнэтийн ДЦС-уудад нийлүүлсэн бөгөөд гэрээгээр төлөвлөсөн хэмжээнээс 51,7 мян.тн нүүрс илүү нийлүүллээ.

Харин Эрдэнэт Гок, Эрэл цемент, УБ Төмөр зам зэрэг гэрээт байгууллагуудад нийлүүлэх нүүрсний чанараас шалтгаалан төлөвлөсөн хэмжээнээс дутуу нийлүүллээ.

2014 оны бизнес төлөвлөгөөгөөр жилдээ 10,827,782,0 мян.төг-ийн хөрөнгө оруулалт хийхээс 9,046,941,9 мян.төг-ийн хөрөнгө оруулалт хийсэн.

Үүнд: 2014 онд Доосан маркын экскаватор 1, Маяти маркын авто машин 4, Геологийн программ гэх мэт нийт 722,985,145.49 төгрөгийн биет хөрөнгө, нийт 257,006,629.80 төгрөгийн биет бус хөрөнгө авсан бөгөөд 2,585,322,680.98 төгрөгийн капиталжуулсан хөрөнгө байна.

2014 онд нэмэгдсэн нийт үндсэн хөрөнгө 4,304,594,041.77 төгрөг, угаах үйлдвэртэй холбоотой 4,742,367,946,946.00 төгрөг, нийт 9,046,941,987.77 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Мөн онд хүү, элэгдэл хорогдол татварын өмнөх ашгийг 8,331,629,0 мян.төг-өөр тооцож төлөвлөснөөс нүүрс борлуулалтын төлөвлөгөө тасарч, хөрс хуулалтыг үлэмж нэмэгдүүлснээр 313,256,6 мян.төг-ийн алдагдалтай ажилласан.

- ❖ Компанийн ТУЗ-ийн хурлаар аудитын компаниар “Эрнст Энд Янг Монголиа” ХХК-тай гэрээ байгуулж ажиллахаар шийдвэр гарсан. Компанийн гүйцэтгэх удирдлага “Эрнст Энд Янг Монголиа” ХХК-тай гэрээтэй ажилласнаар “Эрнст Энд Янг” аудитын компани 2014 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт хийж байна.
- ❖ Мөн онд ТУЗ-ийн хурлаар зайлшгүй “Зээл авах тухай” асуудлаар шийдвэр гаргаж байсан. Үүнд: НАКО түлш ХК, нүүрс угаах үйлдвэр, холбогдох дэд бүтцийг худалдан авах, угсрах ажлыг санхүүжүүлэх зорилгоор Европын сэргээн босголт хөгжлийн бакнаас 10,0 сая ам.долларын зээл авах гэрээ хийгдэж 5,0 сая ам.доллар дансанд орж ирсэн.  
Мөн ТУЗ-ийн хурлын шийдвэр гарч Файрбөрд Инвестмент компаниас дээрхи зорилгоор 5,0 сая ам.долларын зээл авах хөрвөх гэрээ байгуулснаар 2,5 сая ам.доллар авсан. Энэ нь тухайн үеийн ханшаар 5,0 сая ам.доллар (1796,01 төг) – 8,980,050,000 төгрөг, 2,5 сая ам.доллар (1796,01 төг) 4,490,025,000 төг бөгөөд үүнээс нүүрс баяжуулах үйлдвэр худалдан авах, угсралт суурилуулалт, зөвлөх үйлчилгээний төлбөр гэх мэтэд 7,518,615,500.00 төгрөг, НАКО ХК утаагүй түлшний үйлдвэрийн барилгын өөрчлөх загвар, сайжруулалтын зардалд 366,390,858.00 төгрөг, уурхайн грейдер, ачигч гэх мэт тоног төхөөрөмж худалдан всан зардалд 367,349,871.60 төгрөг, нүүрс баяжуулах үйлдвэрийн нэмэлт тоног төхөөрөмж, түүнтэй холбогдон гарсан бусад ажил үйлчилгээний зардалд 858,558,290.60 төгрөг, мөн уг үйлдвэртэй холбогдон гарсан

- Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв зэргийг хэлэлцүүлэн асуудал тус бүрээр тогтоол гаргасан байна.

Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах асуудлыг оруулж мэдээлж танилцууллаа.

Уг хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 81,9 хувь нь оролцож , 8,328,692 ширхэг санал ирүүлснээс, эрх бүхий хувьцааны 8325,875 ширхэг санал хүчин төгөлдөр байсан бөгөөд 99,99-100,0 хувийн саналаар хурлаас гарах тогтоолыг баталсан байна.

- ❖ “Шарын гол” ХК нь 2014 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 10 231 389 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 1057 хувьцаа эзэмшигч манай хувьцааг эзэмшиж байна.  
Компанийн хувьцаа нь “Би Ди Сек”, “Нэйшил Секюртис ҮЦК” зэрэг брокер диллерийн компаниудад төвлөрч байгаа бөгөөд 5,0 хувиас дээш багцыг 6 эзэмшигчид эзэмшиж байна.

Компанийн ТУЗ нь Монгол улсын компанийн тухай хууль, компанийн дүрэм, холбогдох дүрэм журмыг үндэс болгон компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшүүлэн, компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бүрдүүлж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийг ханган ажиллаж олон улсын стандартад нийцсэн уул уурхайн компани болох гол зорилготой ажиллаж байгаа болно.